

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газар

2024 оны XI сар

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын тогтоол							
1	1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр	Худалдан авах ажиллагааны газар нь МУ-ын ЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн □” Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай “□□ 7 дугаар тогтоол, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 165 дугаар тогтоол, Аймгийн Засаг Даргын 2021 оны “Монгол хэлний талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай ” А/246 дугаар захирамжын хэрэгжилт , Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын 7.1.1 дэх арга хэмжээ “Өв соёлоо эрхэмлэж, үндэсний бичгээ сурцгаая-2024” аяны хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна. Дээрх ажлын хүрээнд "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийн хөтөлбөрийн хүрээнд газрын даргын 2024 оны "Монгол бичгийг хэрэглээг нэмэгдүүлэх тухай" А/17 дугаар тушаалаар Монгол бичгийн стандартыг мөрдүүлэн хэвшүүлэх бэлтгэл ажлын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг бүрэн ханган ажиллаж байна. Худалдан авах ажиллагааны нийт албан хаагчид 7 хоног бүрийн Баасан гарагт Хүмүүн бичиг сониныг уншиж, монгол бичгийн унших, бичих чадвараа сайжруулан	100%	100%	

			хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	ажиллаж байна. Мөн албан хаагчдын монгол бичгийн унших чадварыг сайжруулах зорилгоор минутын уншлагыг тогтмол хийж, Монгол бичгийн буланг тогтмол баяжуулан ажиллаж байна. Албан хаагч бүр өөрийн боловсруулсан албан бичгийн төслийг крилл монгол бичгээр боловсруулах хянуулах ажлыг нийт албан хаагчдад хэвшил болгосон. Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөл, Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулж буй архив, албан хэрэг хөтлөлийн албан хаагчдад зориулсан 30 хоногийн сургалтад байгууллагын архив бичиг хэргийн ажилтан тогтмол хамрагдаж байна. Байгууллагын албан хаагчид монгол бичгийн цахим хичээл, цахим гарын авлагуудыг бие даан судалж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 6 файл			
2	2	2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай 2023-02-08 Дугаар 2023_49	Х-1.2. Шүгэл үлээх үйл ажиллагааг бүх талаар дэмжих хөдөлгөөн зохион байгуулж, авлигыг үл тэвчих, үл эвлэрэх хандлагыг төлөвшүүлэх, олон нийтийн дэмжлэг авах;	Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 7 арга хэмжээтэйгээр төлөвлөж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.Төрийн албан хаагч нь өргөсөн тангарагтаа үнэнч байж, төрийн хуулийг чанд мөрдөж шударга ёс ил тод байдлыг дээдлэн ёс зүйтэй төрийн албыг манлайлан ажиллахаа мэдэгдэн гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна. Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын төрийн захиргааны 2 албан хаагч хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийг Авилгатай тэмцэх газрын цахим системд хуулийн дагуу хугацаанд нь тайлагнан ажилласан. Газар нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн дагуу улс, аймаг сумын хэмжээнд тендер зарлах нийт 177 төсөл арга хэмжээнээс аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих	100%	100%	

			тендер зарлах 60 төсөл арга хэмжээнээс захиалагч байгууллагын шийдвэрээр 53 удаагийн үнэлгээний хороог байгуулан давхардсан тоогоор 310 гишүүний мэдээллийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын батлагдсан хавсралтын дагуу худалдан авах ажиллагааны системд хуулийн хугацаанд нь тайлагнасан. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 1 файл			
	3	Х-1.3. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах, иргэд, хувийн хэвшлийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах.	Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь ТБОНӨХБАҮХАТХуулийн дагуу "Өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмын дагуу тендерт оролцохыг сонирхсон этгээдэд тендерийн урилга, баримт бичиг, зураг-төсөв, батлагдсан техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын мэдээллийг цахим системд нийтлэж, тендерийн нээлтийг цахимаар зохион байгуулж, оролцсон аж ахуйн нэгж, иргэнд шалгарсан эсхүл шалгараагүй шалтгаан, нөхцлийг албан бичгээр хүргүүлж, үнэлгээний хорооны хурал, хурлын тэмдэглэл, зөвлөмж, захиалагч байгууллагын шийдвэр, тендерийн үр дүн, гэрээ, бараа, ажил, үйлчилгээ хүлээлгэн өгсөн тухай акт, баримтыг цахим системд тасралтгүй нийтлэн ажиллаж байна. 2024 оны 11- р сарын байдлаар аймгийн Худалдан авах ажиллагааны газарт аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих нийт 53 төсөл арга хэмжээнд үнэлгээний хороодыг байгуулан давхардсан тоогоор 310 гишүүний “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-д гарын үсгээр баталгаажуулан тухай бүр цахим системд ил тод мэдээлж ажилласан.	100%	100%	

				Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 1 файл			
3	4	Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023-08-30 Дугаар 2023_312	5. Худалдан авах ажиллагааны газар байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохих журмын дагуу зохион байгуулж, албан хаагчдыг орон тоо, цалингийн сан, эд хөрөнгийн хамт Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн ажиллуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 312 дугаар тогтоолоор Худалдан авах ажиллагааны газар байгуулах чиглэл өгч аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/758 дугаар захирамжаар тус газрын дүрэм, бүтэц, орон тоог батлан, орон нутгийн өмчийн газраас төрийн захиргааны 2 албан хаагчийг шилжүүлэн ажиллуулж зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн шинэ бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байна. Улмаар хууль, тогтоомжийн хүрээнд орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулах, хуулийн хэрэгжилтийг хангуулж чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан бүтэц орон тооны дагуу хүний нөөцийг бүрдүүлэх болон байгууллагын үйл ажиллагааг жигдрүүлэхэд дотоод нөөц бололцоонд тулгуурлан 42,5 сая төгрөгийн зарцуулж шаардагдах тавилга, суурин компьютер тоног төхөөрөмжийг худалдан авсан. Одоогоор Төрийн захиргааны 7, төрийн үйлчилгээний 3 ажилтан албан хаагчтай хууль тогтоомжийн дагуу үндсэн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 1 файл	100%	100%	
4	5	Журам	3. Энэ журмыг үйл	Худалдан авах ажиллагааны газар нь байгууллагын	100%	100%	

		батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_77	ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй. (Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам")	хэмжээний мэдээллийг Үндэсний дата төв УТҮГ-тай хамтран гэрээний үндсэн дээр http://to.spa.gov.mn домайн хаяган дээр цахим хуудсаа байршуулах, дотоод үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл болон худалдан авах ажиллагааг зохион байгуулсан нийт баримт файлаар сан бүрдүүлэн ажиллаж байна. Аймгийн худалдан авах ажиллагааны газар нь http://tender.gov.mn худалдан авах ажиллагааны цахим хуудаснаас аймгийн Худалдан авах ажиллагааны мэдээллийг 10 хоног тутамд нэгтгэн авч аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, сар бүрийн мэдээг тогтсон хугацаанд хүргүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг Даргын Зөвлөлийн хурал, Аймгийн ИТХуралд аймгийн Худалдан авах ажиллагааны явцын мэдээллийг танилцуулан ажилласан. Худалдан авах ажиллагааны явцын инфографик мэдээллийг http://tov.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулж ажиллалаа. Цаашид Худалдан авах ажиллагааны явцын мэдээг сумдаас google form ашиглан нэгтгэн авч мэдээллийг цахим хэлбэрээр боловсруулах ажлын бэлтгэлийг ханган ажиллаж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 2 файл			
5	6	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ХҮII дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган Худалдан авах ажиллагааны газар нь төрийн захиргааны 7 албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг 50 хувиар, төрийн үйлчилгээний 3 албан хаагчдад 10хувиар тооцон журмын дагуу сар бүр олгож байна. Аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны 11-р сард нийт албан хаагчдад орон нутагт ажилласний	100%	100%	

			батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)	нэмэгдэл өссөн дүнгээр 30.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн			
6	7	Жагсаалт батлах тухай 2024-04-17 Дугаар 2024_162	3. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Ерөнхий гэрээний аргаар тендер шалгаруулалт зохион байгуулахаар төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авах 480.0 сая, төгрөгийн өртөг бүхий захиалгыг хийж 3 нэр төрлийн 191 ширхэг барааг 221.5 сая, төгрөгөөр худалдан авах гэрээг байгуулж ажилласан. Үүнд: 1.Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж (Төв) төсөл, арга хэмжээг 107.5 сая, төгрөгөөр Ай Ти Зон ХХК; 2.Хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын төсөл, арга хэмжээг 9.8 сая, төгрөгөөр Бодь-Электроникс ХХК; 3. Багш бүрд компьютер төсөл арга хэмжээг 104.1 сая, төгрөгөөр Би Си Ти ХХК; 4.Гэр төсөл хэрэгжүүлэхэд 199.8 сая, төгрөгөөр Жанцан ХХКомпани Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 1 файл	100%	100%	
7	8	Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг	3.. “Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем”-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн	“Худалдан авах ажиллагааны газрын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнээс Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн систем-ХНУМТ” цахим систем, Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системүүдэд	100%	100%	

		дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196	мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай	газрын нийт төрийн жинхэнэ /7/ болон үйлчилгээний /3/ албан хаагчдийн мэдээллийг үнэн зөв оруулж хүний нөөцийн удирдлага мэдээллийн системийн баяжилт, цалин нэмэгдлийн санг шинэчлэн санхүүгийн программтай холбон ажиллаж хэвшсэн. 2024 оны 11 дүгээр сард эхийн чөлөөний хугацаа дуусч ажилдаа орсон төрийн захиргааны нэг албан хаагчийн мэдээллийг цахим системд бүрэн оруулсан. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн			
8	9	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	4.. Төрийн байгууллага хоорондоо төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын систем (Docx)-ийг ашиглаж байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгож, шүүх, прокурор, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог төрийн байгууллагын удирдлагуудад тус тус зөвлөсүгэй.	Худалдан авах ажиллагааны газар нь ERP системд суурилсан албан бичиг солилцооны дундын систем (DOCX) -ийг ашиглахаар - 2024 оны 05 дугаар сард Үндэсний дата төвд гарган батлуулж 2024 оны 06 дугаар сард Архивын ерөнхий газраар хэвлэмэл хуудсаа батлуулсан. 2024 оны 08 дугаар сард Тридум Кэй ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан тоон гарын үсгийг авч үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн. Байгууллагын урсгал зардлаас 65,000 төгрөгийг зарцуулсан. Төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад албан бичгийг илгээх, хүлээн авахдаа албан бичиг солилцооны дундын системийг туршилтаар нэвтрүүлэх ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	100%	
9	10	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай 2024-10-02 Дугаар 2024_109_1	2. Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолын хавсралтаар баталсан ёс зүйн хэм хэмжээнд нийцүүлэн батлан хэрэгжүүлэх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг	Худалдан авах ажиллагааны газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/04 тоот тушаалаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг баталсан. Уг журмын ерөнхий зүйлийн 2 дахь заалт, Дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалтын 1,5 дахь заалт, Хүний нөөц бүрдүүлэлт, ажилд авах, ажлаас чөлөөлөхтэй	100%	100%	

			төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай холбогдох хөдөлмөр зохион байгуулалт, цалин хөлс хэсгийн 2.8 болон 2.11, Хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлага 8.2 дахь заалт, Ёс. Ажил олгогчийн эрх, үүргийн 9.3 болон 9.5 дахь заалтуудад МУ-ын Засгийн Газрын 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 109 дүгээр тогтоолын 2.3 дахь заалт буюу Хууль ёс, шударга ёсыг дээдлэн сахих, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд хэм хэмжээ, 2.4 Албан үүргээ гүйцэтгэхдээ гаргасан өөрийн буруутай үйлдэл, эс үйлдэхүйн төлөө ёс зүйн хариуцлага хүлээдэг байх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд хэм хэмжээ, 2.7 Албан үүргээ гүйцэтгэхдээ бусдад аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх ёс зүйн нийтлэг хэм хэмжээ 2.1.Ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилж, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин биелүүлэх хүрээнд хэм хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлж байна. Байгууллагын ёс зүйн дэд хороо нь газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдаж Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, МУ-ын ЗГ-ын 2024 оны 109 дүгээр тогтоол, МУ-ын ёс зүйн хорооны тогтоол, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмын дагуу ажиллаж байна. 2024 оны 11-р сарын байдлаар Худалдан авах ажиллагааны газрын Ёс зүйн хороонд ирсэн өргөдөл гомдолгүй болно. Байгууллагын нийт албан хаагчид МУ-ын Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 7:4:10 вебинар сургалтад 7 хоног бүрийн Пүрэв гарагт тогтмол хамрагдаж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн			
--	--	--	---	--	--	--

				Хавсралт нийт : 3 Файл : 1 Зураг : 2			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
10	11	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулах Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэхээр байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон байгууллагын нэгдсэн төлөвлөгөөний 1.6 дахь хэсэгт тусган ажиллаж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 2 файл	100%	100%	
11	12	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэл 2024-04-03 Дугаар 2024_13	22.6.1.. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тус тус авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 51,737.9 сая, төгрөгийн 143 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг хариуцуулж, тайлант оны жилийн эцэст 48,424.7 сая, төгрөгийн 129 төсөл, арга хэмжээнд тендер зарласан байна. Үүнээс: 1.Захиалагч байгууллага тендер шалгарсан гүйцэтгэгчтэй 116 төсөл, арга хэмжээнд 42,223.1 сая, төгрөгийн гэрээг байгуулж, 1,949.3 сая, төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан. 2.Тендерийн нээлт хийгдсэн хуулийн дагуу үнэлж байгаа 360.0 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ байна. 3.Тендерийг зарласан буюу нээлт хийгдэхээр хүлээгдэж байгаа 3,902.6 сая, төгрөгийн 9 төсөл, арга хэмжээ байна. Аймгийн Засаг даргын 2024 оны А/01, А/551 дүгээр захирамжаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд гэрээний гүйцэтгэл хангуулах, салбарын норм, стандартын хүрээнд тогтмол хяналт тавих, ажиллах захиалагч байгууллагыг томилж, зам,	100%	100%	

			нарт;(Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн 2024 оны 1 дүгээр улирлын явц, гүйцэтгэлийн талаар)	барилга угсралтын ажлын гүйцэтгэлд үе шатны хуваарийн дагуу хяналт тавьж ажиллуулж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 1 файл			
--	--	--	--	--	--	--	--